

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

Агуулга.....	1
1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал.....	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн Хөгжлийн Банк



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

“ХҮҮХЭД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ
ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ
ТЭМЦЭХ БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖИЙН
ТӨСӨЛ”-ИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Б.ДАРЬХАНД ТАНАА

2020.04.30 № 06/1446
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх буцалтгүй тусламжийн төсөл”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх буцалтгүй тусламжийн төсөл”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх буцалтгүй тусламжийн төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

“Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх буцалтгүй тусламжийн төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн зохицуулагч Б. Дарьханд Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн заавар аргачлалд нийцсэн санхүүгийн программ хангамж ашиглан нягтлан бодох бүртгэл хөтлөх, Нийгмийн даатгалын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийг дагаж мөрдөх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх буцалтгүй тусламжийн төсөл”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх буцалтгүй тусламжийн төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 23-наас 2020 оны 04 дүгээр сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн Далайван Аудит ХХК-ийн захирал Ц.Жигдэн хянан удирдаж, чанарын хяналтын менежер М.Болормаа, аудитор Ц.Ганболд, аудиторовын туслах Э.Төгөлдөр нар хэрэгжүүлэв.

“Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх буцалтгүй тусламжийн төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 10 тоот албан бичгээр хуулийн хугацаанд хүргүүлсэн байна. Далайван Аудит ХХК нь 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 29 тоот албан бичгээр төслийн нэгжийн санхүүгийн тайланг хүлээн авч аудитын ажлыг эхлүүлсэн.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын Засгийн Газар, Азийн Хөгжлийн Банк (АХБ) хооронд 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан буцалтгүй тусламжийн гэрээнд “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийг санхүүжүүлэх зорилгоор “Ядуурлыг бууруулах Японы сан”-гаас 3,000,000 ам.долларын буцалтгүй тусламжийг АХБ-аар дамжуулан санхүүжүүлэхээр тусгасан байна. Буцалтгүй тусламжийн дуусгавар болох хугацаа нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр эсвэл Хүлээн авагч болон АХБ шинээр харилцан тохирсон өдөр байна. Хамтран гүйцэтгэгч тал буюу Монгол Улсын Засгийн газраас мөнгөн бус хэлбэрээр 200,000 ам.долларын санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр тохиролцсон байна.

Төслийн зорилго нь:

“Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх буцалтгүй тусламжийн төсөл”-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэхэд оршино.

Үндсэн үйл ажиллагааны чиглэл:

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, даван туулагчдад хамтарсан багаар тусламж үйлчилгээ болон амьжиргааны дэмжлэг үзүүлэх, Гэр бүлийн хүчирхийллийг даван туулагчдыг хамгаалалд авах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээсэн гол албан тушаалтан болон ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх, Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, мэдээлэх болон хохирогч, даван туулагчдыг хамгаалах гол оролцогч талуудын зан үйлийг өөрчлөх, сайжруулах.

“Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх буцалтгүй тусламжийн төсөл”-ийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Засгийн газрын 2016 оны 176 тоот тогтоолоор батлагдсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах, журам”
- Сангийн сайдын 2007 оны 326 тоот тушаалаар батлагдсан “Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрэлдэхүүн болох Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн

хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, засгийн газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”

- Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал

Тайлант хугацаанд төслийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон;

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Төсөл нь өөрийн үйл ажиллагаанд тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулаагүй байна.

Төсөл хэрэгжүүлэх нэгж нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Инфосистемс” ХХК-ийн гаргасан “Пакс” программ хангамж ашигладаг.

Төслийн нэгжийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

Төсөл нь төлөвлөсөн үйл ажиллагааг тогтоосон хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлэх, зээлийн хөрөнгийг зорилгын хүрээнд үр ашигтай зарцуулах, хэрэгжилтэд хяналт тавих, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, ил тод байдлыг хангахын тулд төслийн гүйцэтгэлийн хяналт, санхүүгийн хяналт, худалдан авах үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлдэг. АХБ болон Төслийн гүйцэтгэгч байгууллагаас төслийн үйл ажиллагааны үе шат бүрт хяналт тавьж ажилладаг байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар төслийн нэгжийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 2 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн “нийт зардал”-ыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 195,757.8 мянган төгрөгөөс тооцон 3,915.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж,

баталгаажууллаа. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг хэвээр үлдээсэн болно.

Нийт зардлын дүнг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төсөл хэрэгжүүлэх нэгж нь АХБ-ны буцалтгүй тусламжийн санхүүжилтээр орлогын эх үүсвэрийг бүрдүүлдэг тул зардлаас тооцох нь илүү оновчтой гэж үзсэн.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх буцалтгүй тусламжийн төсөл” нь 2019 оны 6 дугаар сараас үйл ажиллагаа нь эхэлсэн тул тайлант хугацааны эхний үлдэгдэл байхгүй.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

<i>/мянган төгрөг/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	517,848.02	517,848.02
Үндсэн хөрөнгө	-	103,799.09	103,799.09
Хуримтлагдсан элэгдэл	-	(1,018.37)	(1,018.37)
Биет бус хөрөнгө	-	8,450.00	8,450.00
Хуримтлагдсан элэгдэл	-	(81.03)	(81.03)
Нийт хөрөнгө	-	628,997.71	628,997.71
Богино хугацаат өр төлбөр	-	20.00	20.00
Тайлант үеийн үр дүн	-	628,977.71	628,977.71
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	-	628,997.71	628,997.71

Мөнгөн хөрөнгө: Тайлант хугацааны эцэст төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл 19,441.0 мянган төгрөг, валютын харилцах дансны үлдэгдэл 498,407.0 мянган төгрөг байна.

Үндсэн хөрөнгө: АХБ-ны санхүүжилтээр төслийн нэгжийн үйл ажиллагаанд зориулан 60,588.5 төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, 33,116.5 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн. Тайлант хугацаанд нийт 1,018.37 мянган төгрөгийн элэгдэл тооцож зардлаар бүртгэсэн.

Биет бус хөрөнгө: АХБ-ны санхүүжилтээр төслийн нэгжийн нягтлан бодох бүртгэлийг хөтлөхөд зориулан 8,450.0 төгрөгийн санхүүгийн программ хангамжийг худалдан авч биет бус хөрөнгөөр бүртгэсэн. Тайлант хугацаанд нийт 81.03 мянган төгрөгийн хорогдуулалт тооцож зардлаар бүртгэсэн.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

“Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх буцалтгүй тусламжийн төсөл” нь төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулагдахаас өмнө өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг санхүүжүүлэх арга хэмжээнд зориулан тайлант онд 504,990.3 мянган төгрөгийн төсөв батлуулжээ.

Төсвийн орлогын гүйцэтгэл 798,870.0 мянган төгрөг буюу төлөвлөснөөс 293,879.7 мянган төгрөгөөр давсан байна. Энэ нь төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулахаас өмнө

Сангийн яамны Хөгжийн санхүүжилтийн газраас урьдчилан тооцож баталсан тайлант оны төсөв болон төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулагдсанаар төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө, худалдан авалтын төлөвлөгөөнд үндэслэн бодитойгоор тооцож татан авсан санхүүжилтийн зөрүүнээс орлого давсан байна. Энэ санхүүжилтийн зөрүүг Сангийн яамны Хөгжийн санхүүжилтийн газраас хянаж баталсан.

Хүснэгт 2. Төслийн орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Тусламжийн санхүүжилт	504,990.3	798,870.0	(293,879.7)	158.2
Нийт дүн	504,990.3	798,870.0	(293,879.7)	158.2

Хүснэгт 3. Төслийн зардал

/мянган төгрөг/

Зарцуулалтын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Урсгал зардал	210,000.0	183,929.8	26,070.2	87.6
Хөрөнгийн зардал	294,990.3	112,249.1	182,741.2	38.1
Нийт дүн	504,990.3	296,178.9	208,811.4	58.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 2 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж нийт 7 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 162,398.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 158,889.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,508.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

1. Үндсэн хөрөнгө:

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө бэлтгэхтэй холбоотой 10,093.7 мянган төгрөгийн тээврийн зардал гарсан байна. Уг зардлыг хөрөнгийн өртгийг нэмэгдүүлэлгүй тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

Энэ нь "УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө"-ийн стандарттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

2. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал:

Үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцохдоо ашиглалтад хүлээн авсан өдрөөс биш тухайн худалдан авсан сарын эхний өдрөөс элэгдэл тооцсоноос үүдэн 614.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал илүү бүртгэсэн.

Энэ нь "УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө"-ийн стандарттай нийцэхгүй, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

3. Монгол Улсын Засгийн газрын санхүүжилт:

Монгол Улсын Засгийн газрын санхүүжилт /бусад хөрөнгө оруулалт/ 1,000.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд журнал бичилт хийхгүйгээр шууд санхүүгийн тайланд нэмж тайлагнасан.

Энэ нь “үнэн зөв байх”, “Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

4. Зардлын ангилал:

Санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардал 147,180.9 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлаар буруу ангилан тайлагнасан.

Энэ нь “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангаагүй, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн “Үнэн зөв байх” зарчимтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

Аудитаар илэрсэн 3,508.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар дор дурдсан асуудлуудыг анхаарч үзэх шаардлагатай. Үүнд:

- Төсвийн тухай хуульд олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх төслийн нэгж нь төсвийн байгууллага байхаар зааснаар нягтлан бодох бүртгэлээ УСНББОУС-ын дагуу бүрэн аккруэл сууриар бүртгэхтэй холбоотойгоор олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаанд тохирсон нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын нэгдсэн заавар, аргачлалыг Сангийн яамнаас тусгайлан гаргах хэрэгтэй байна. Уг заавар, аргачлалд төслийн нэгж нь АХБ-ны зарцуулалтын үндсэн процедур болох шууд төлбөр, урьдчилгаа төлбөр, нөхөн дүүргэлтийг аккруэль сууриар хэрхэн хүлээн зөвшөөрч бүртгэж тайлагнах, хүлээн авсан болон зарцуулсан санхүүжилтэнд гадаад валютын ханшийг хэрхэн ашиглах, төслийн санхүүжилтээр бий болсон биет болон биет бус хөрөнгийг элэгдүүлэх хугацаа болон арга, төслийн санхүүжилтээр хийгдэж байгаа барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг хэрхэн хуримтлуулан бүртгэх, хөрөнгийг төсөл дуусахад төрийн өмчид шилжүүлэх;
- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд шаардсан мэдээллийг бүрэн оруулсан эсэхийг хянах;

2.12. Шилэн дансны мэдээлэл

“Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх буцалтгүй тусламжийн төсөл” нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу 47 мэдээлэл оруулах ёстой байснаас 44 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

“Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх буцалтгүй тусламжийн төсөл” нь 2019 оны 6 дугаар сараас эхлэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн тул өмнөх аудитын дүгнэлт тайлан байхгүй.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх буцалтгүй тусламжийн төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

“Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх буцалтгүй тусламжийн төсөл”-ийн 2019 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Санхүүгийн программ хангамжийн талаар

3.1.1 Илрүүлэлт:

Төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Инфосистемс” ХХК-ийн “Пакс” санхүүгийн программ хангамж ашигладаг. Тус программ нь Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, УСНББОУС-д нийцээгүй, АХБ-ны Зарцуулалтын журмын шаардлагын дагуу мөнгөн сууриар нягтлан бодох бүртгэл хөтлөхөөр тохируулга хийгдсэн байна.

Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байх, тодруулга ба толилуулга, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйлийн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Төслийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал буруу, алдаатай бэлтгэгдэх;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төслийн санхүүгийн программыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-ын шаардлагад нийцүүлсэн байдлаар шинэчлэх, холбогдох өөрчлөлт оруулах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Үнийн саналын харьцуулалтын аргаар шаардлага хангаж шалгарсан “Инфосистемс” ХХК-ийн “Пакс” санхүүгийн программ хангамжийг ашиглах гэрээг 2019.12.10-нд байгуулж Санхүүгийн программын суурь баазыг 2019.12.17-нд хүлээн авсан. Санхүүгийн программ хангамжийг өөрийн төслийн онцлогт тохирсон хөгжүүлэлт, шинэчлэлтийг хийх ажлыг тус байгууллагын программ хөгжүүлэлтийн багтай цаг тухай бүрт холбогдож хийгдэж явж байна.

3.2 Нийгмийн даатгалын шимтгэл

3.2.1 Илрүүлэлт:

Төслийн нэгж нь 2019 оны 6 дугаар сарын 5-ны өдөр төслийн зохицуулагч, санхүүгийн ажилтан, худалдан авалт хариуцсан ажилтантай хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан. 2019 оны 6 болон 7 дугаар саруудад төслийн нэгжийн 3 ажилтанд нийт 19,238.0 мянган төгрөгийн цалин тооцож 8 сард олгохдоо Ажил олгогч болон Даатгуулагчийн НДШ 3,508.7 мянган төгрөгийг суутгаагүй зөвхөн ХХОАТ суутган тооцож цалинг олгосон.

Энэ нь “Нийгмийн даатгалын тухай хууль”-ийн 1 дүгээр бүлгийн 4 дүгээр зүйлийн 2-т “Өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн” заавал даатгуулна гэсэн заалттай нийцээгүй, “Иж бүрэн байх”, “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Нийгмийн даатгалын тухай хууль зөрчигдөх;

3.2.3 Өгсөн зөвлөмж:

“Нийгмийн даатгалын тухай хууль”-ийг дагаж мөрдөх, цаашид алдааг дахин давтахгүй байх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төсөл хэрэгжүүлэх нэгж 2019 оны 6 сард байгуулагдахад төслийн данс нээгдээгүй, санхүүжилт орж ирээгүй байсан. Үүнтэй холбоотойгоор харьяа Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс Төсөл хэрэгжүүлэх нэгжийг шимтгэл төлөгч байгууллагаар бүртгэж аваагүй, тайлан өгөх эрх нээж өгөхөөс татгалзсан. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн санхүүжилт АХБ-наас 8 дугаар сард орж ирж шимтгэлийг тушааснаар Нийгмийн даатгал төлөгч байгууллагаар бүртгүүлж, 8 дугаар сард тайлан тушаах эрх үүссэн болно.

3.3 Шилэн дансны мэдээллийн талаар

3.3.1 Илрүүлэлт:

Төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу нийт 47 мэдээлэл оруулахаас 44 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

3.3.2 Эрсдэл:

Шилэн дансны тухай хууль зөрчих;

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу мэдээллийг тогтсон хугацаанд нь бүрэн гүйцэт оруулах.

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Шилэн дансны мэдээллийг цаг тухай бүрт оруулж явж байгаа боловч аливаа хугацаандаа оруулсан мэдээллийг засварлахад хугацаа хоцорсонд тооцогддог, хэзээ мэдээг оруулсан, хэзээ засварласан гэсэн цаг хугацааны санамжгүй байгаа нь шилэн дансны цахим систем нь учир дутагдалтай байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		517,848,022.05
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		517,848,022.05
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө		517,848,022.05
31210	Төгрөг		19,441,001.49
31211	Төрийн сангийн харилцах		19,441,001.49
31220	Гадаад валют		498,407,020.56
31223	Арилжааны банк дахь харилцах		498,407,020.56
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		111,149,687.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		111,149,687.20
39200	Биет хөрөнгө		102,780,714.60
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)		67,110,550.00
39206	Хуримтлагдсан элэгдэл		(827,390.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		36,688,536.36
39208	Хуримтлагдсан элэгдэл		(190,981.42)
39300	Биет бус хөрөнгө		8,368,972.60
39301	Програм хангамж		8,450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(81,027.40)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		628,997,709.25
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		20,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		20,000.00
41300	Өглөг		20,000.00
41360	Бусад өглөг		20,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		20,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		628,977,709.25
51	Засгийн газрын хувь оролцоо		628,977,709.25
51200	Хуримтлагдсан үр дүн		628,977,709.25
51210	Өмнөх үеийн үр дүн		-
51220	Тайлант үеийн үр дүн		628,977,709.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		628,997,709.25

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		812,806,930.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		812,806,930.00
120	Нийтлэг татварын бус орлого		13,936,930.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		13,936,930.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		13,916,930.00
120009	Бусад орлого		20,000.00
122	Тусламжийн орлого		798,870,000.00
122001	Хандив тусламж /дотоод/		-
122002	Хандив тусламж /гадаад/		798,870,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		185,049,212.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ		185,049,212.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		185,049,212.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		147,180,999.00
210101	Үндсэн цалин		147,180,999.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		15,992,874.89
210201	Тэтгэврийн даатгал		15,992,874.89
2104	Хангамж, бараа материалын зардал		4,756,360.00
210401	Бичиг хэрэг		3,656,860.00
210402	Тээвэр, шатахуун		391,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		708,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		16,019,579.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		15,982,950.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		36,629.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,099,399.16
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		1,099,399.16
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		627,757,717.95
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		16,228,214.82
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз		16,228,214.82
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		15,008,223.52
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз		1,091,293.52
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал		13,916,930.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		628,977,709.25

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

			/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		798,890,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		798,890,000.00
120	Нийтлэг татварын бус орлого		20,000.00
120009	Бусад орлого		20,000.00
122	Тусламжийн орлого		798,870,000.00
122001	Хандив тусламж /дотоод/		
122002	Хандив тусламж /гадаад/		798,870,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		183,929,812.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ		183,929,812.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		183,929,812.89
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		16,035,374.89
2104	Хангамж, бараа материалын зардал		4,756,360.00
210401	Бичиг хэрэг		3,656,860.00
210402	Тээвэр, шатахуун		391,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		708,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		163,138,078.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		614,960,187.11
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		112,249,086.36
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		112,249,086.36
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		112,249,086.36
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		15,136,921.30
14	Бусад эх үүсвэр		16,228,214.82
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз		16,228,214.82
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		1,091,293.52
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз		1,091,293.52
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		517,848,022.05
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		517,848,022.05

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	628,977,709.25	628,977,709.25
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	628,977,709.25	628,977,709.25

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	504,990,300.00	296,178,899.25	208,811,400.75	58.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	210,000,000.00	183,929,812.89	26,070,187.11	87.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	210,000,000.00	183,929,812.89	26,070,187.11	87.59
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,191,200.00	16,035,374.89	7,155,825.11	69.14
210201	Тэтгэврийн даатгал	23,191,200.00	16,035,374.89	7,155,825.11	69.14
2104	Хангамж, бараа материалын зардал	14,040,000.00	4,756,360.00	9,283,640.00	33.88
210401	Бичиг хэрэг	6,840,000.00	3,656,860.00	3,183,140.00	53.46
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.00	391,500.00	2,608,500.00	13.05
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,200,000.00	708,000.00	3,492,000.00	16.86
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	172,768,800.00	163,138,078.00	9,630,722.00	94.43
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	172,768,800.00	163,138,078.00	9,630,722.00	94.43
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	294,990,300.00	112,249,086.36	182,741,213.64	38.05
220001	Барилга байгууламж	169,982,700.00	-	169,982,700.00	0.00
221001	Их засвар	-	-	-	-
222001	Тоног төхөөрөмж	115,707,600.00	103,799,086.36	11,908,513.64	89.71
223001	Бусад хөрөнгө	9,300,000.00	8,450,000.00	850,000.00	90.86
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	504,990,300.00	798,870,000.00	(293,879,700.00)	158.20
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	504,990,300.00	798,870,000.00	(293,879,700.00)	158.20
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	504,990,300.00	798,870,000.00	(293,879,700.00)	158.20
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
370001	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	-	-	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	517,848,022.05	(517,848,022.05)	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	-	-	-	-
650010	Гэрээт ажилтан	-	6	-	-

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	“Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх буцалтгүй тусламжийн төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн	Аудитын код:
2020.04.27	Шалгагдсан байгууллагын нэр:		САГ-2020/731/СТА-ТХН
		“Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх буцалтгүй тусламжийн төсөл”	мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгуулл агаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	<p>Төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Инфосистемс” ХХК-ийн “Пакс” санхүүгийн программ хангамж ашигладаг. Тус программ нь Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, УСНББОУС-д нийцээгүй, АХБ-ны Зарцуулалтын журмын шаардлагын дагуу мөнгөн сууриар нягтлан бодох бүртгэл хөтлөхөөр тохируулга хийгдсэн байна.</p> <p>Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байх, тодруулга ба толилуулга, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйлийн заалттай нийцэхгүй байна.</p>	-	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч	Б.Дарьханд
2	<p>Төслийн нэгж нь 2019 оны 6 дугаар сарын 5-ны өдөр төслийн зохицуулагч, санхүүгийн ажилтан, худалдан авалт хариуцсан ажилтантай хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан. 2019 оны 6 болон 7 дугаар саруудад төслийн нэгжийн 3 ажилтанд нийт 19,238.0 мянган төгрөгийн цалин тооцож 8 сард олгохдоо Ажил олгогч болон Даатгуулагчийн НДШ 3,508.7 мянган төгрөгийг суутгаагүй зөвхөн ХХОАТ суутган тооцож цалинг олгосон.</p> <p>Энэ нь “Нийгмийн даатгалын тухай хууль”-ийн 1 дүгээр бүлгийн 4 дүгээр зүйлийн 2-т “Өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн</p>	3,508.7	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч	Б.Дарьханд

	бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн” заавал даатгуулна гэсэн заалттай нийцээгүй, “Иж бүрэн байх, үнэлгээ ба хувиарлалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.				
3	Төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу нийт 47 мэдээлэл оруулахаас 44 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	-	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч	Б.Дарьханд
	Зөвлөмжийн дүн	3,508.7			

